

ЭКОЛОГИЙН СЭДЭВТ НИЙТЛЭЛИЙН ГАРЧИГ, ТҮҮНИЙ НӨЛӨӨ

Л. Ариун\*

\* ХИС, Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхмийн багш, доктор (Ph.D.)

**Түлхүүр үг:** экологийн сэдэв, нийтлэлийн гарчиг, гарчгийн нөлөө, гарчгийн үүрэг.

**А**ливаа гарчиг уншигчийн анхаарлыг татаж, тодорхой нөлөөлөл үзүүлэхэд чиглэгдсэн байдаг. Сэтгүүлч, идэвхтэн бичигчид гарчгийн ач холбогдлыг өндөр үнэлж, нийтлэлээс илүүд үзэх нь цөөнгүй. Сонин хэвлэлийг хүмүүс гарчгаар нь дамжин уншдаг. Сонины дугаарт нийтлэгдсэн материалуудаас өөрт хамгийн хэрэгтэй, хамгийн сонирхолтойг сонгоход гарчиг тусалдаг<sup>1</sup>. Тийм ч учир гарчгийг И.Дамбажав, Л.-Зундуй нар “уншигчдыг сонин сэтгүүлийн агуулга руу хандуулах, чигийг заах луужин”<sup>2</sup> гэж оновчтой тодорхойлсон байдаг.

Хэвлэлд гүйцэтгэх гарчгийн үүргийг эрдэмтэд янз бүрээр тодорхойлсон байдаг. Тухайлбал, доктор Ч.Чойсамба мэдээлэх, чимэглэх<sup>3</sup> гэсэн хоёр үндсэн үүрэгтэй гэж үзээд тэдгээрийг дотор нь дэд үүргүүдэд:

1. Мэдээлэх

1.1. Материалын тухай товч мэдээлэл өгөх

1.2. Уншигчийн сонирхлыг төрүүлэх

1.3. Хэрэгтэй мэдээллээ олж авахад уншигчид туслах

1.4. Шуурхай байдлыг хангаж хөдөлмөрийг хөнгөвчлөх

2. Чимэглэх

2.1. Нүүрийг чимэглэх

2.2. Нэг материалыг нөгөөгөөс тусгаарлах

2.3. Уншигчийн анхаарлыг татах гэж хуваасан байна.

Экологийн нийтлэлийн гарчиг бусад гарчгийн нэг адил нийтлэлийнхээ агуулгыг товч мэдээлэхийн зэрэгцээ, уншигчдын анхаарлыг татаж, нөлөөлөл үзүүлэх зорилго агуулдаг. Тэр тусмаа байгаль орчинд тулгамдаад байгаа асуудлын тухай ойлголт өгч, байгаль орчныг хайрлаж хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулахад уриалах, нөлөөлөхөд гарчиг маш өндөр үүрэг гүйцэтгэдэг. Манай сонин хэвлэлийн экологийн нийтлэлийн гарчиг ямархуу дүр төрхтэй байгаа хийгээд агуулга, хэлбэрийн хувьд яаж ангилж болох, гарчигт ажиглагдаж буй ололт, дутагдлыг илрүүлэхийн тулд өдөр тутмын хэд хэдэн сонины экологийн

нийтлэлийн гарчигт задлан шинжилгээ хийлээ.

Экологийн сэдэвт нийтлэлийн гарчгийн ерөнхий агуулга нь харанга дэлдсэн, сэрэмжлүүлсэн, анхааруулсан өнгө аястай байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал: "Монгол улс Сахарын цөл болоход ганц хуруу дутуу болжээ" ("Үндэсний шуудан", 2010.01.21), "Жирмийн цагаан нуур минь тоосонд дарагдаад ширгэх нь" ("Өнөөдөр", 2008.08.21), "Монгол улс дэлхийд хориглосон химийн бодис хэрэглэж байна" ("Зууны мэдээ", 2003.02.25), "Хүдэрийн байгаль хутганы ирмэг дээр байна" ("Нийгмийн толь", 2008.05.19), "Монгол улсад худалдаалж байгаа хүнсний бүтээгдэхүүний таль хувь нь баталгаагүй" ("Өнөөдөр", 2001.12.06), "2015 онд Туул гол бүрмөсөн ширгэнэ" ("Ардчилал", 2009.04.14), "Монголын тэнгэрт озоны цоорхой үүсэх аюул нүүрлэжээ" ("Өнөөдөр", 2004.05.20) гэх мэтээр гарчигласан экологийн нийтлэл дийлэнх хувийг эзэлж байна. Байгаль орчны хурц асуудалд олон түмний анхаарлыг хандуулж, сэрэмжүүлсэн өнгө аястай байгаа нь нэг талдаа сайшаалтай. Гэвч ус, мод, агаар, ан амьтан гээд хүрээлэн буй орчин бүхэлдээ сүйрчихсэн, дуусчихсан, ширгэчихсэн агуулгатай гарчиг, нийтлэл нь уншигчийг сүйрч буй байгаль орчноо аврахын төлөө ямар нэгэн үйл хийхэд уриалах, чиглүүлэх биш энэ асуудал нэгэнт өнгөрчихсөн юм чинь би юу ч хийгээд нэмэргүй гэсэн сэтгэгдэл төрүүлэхээр байгаа юм. Мөн хэтэрхий сүржин, хэтрүүлэг бүхий ийм гарчиг уншигчдад итгэл үнэмшил төрүүлдэггүй. Үнэхээр иймэрхүү гарчгуудын зарим нь эх бичвэртэй зөрчилдөх нь

бий. Зүй нь тулгараад байгаа бодит байдлыг хэт дэвэргэлгүй дүрслээд, энэ асуудлаас гарч болох арга зам, зөв шийдлийг тусгаж, үүнд уншигч таны оролцоо юу байх вэ гэдгийг бичих хэрэгтэй. Тухайлбал "Уур амьсгалын дулааралд хүн болгон санаа тавих цаг иржээ" ("Зууны мэдээ", 2010.01.28), "Түшээдийн гараас хөрөө сүхийг нь булаая" ("Өнөөдөр", 2010.03.03), "Ногоон хэрэм" л цөлжилтийг зогсооно" ("Өнөөдөр", 2008.05.28), "Туул голыг бохирдлоос аврах боломж байна" ("Үндэсний шуудан", 2010.02.24) зэрэг эерэг агуулга хандлагатай гарчигтай нийтлэл тун цөөн гарч байгааг анхаарууштай юм. ОНМХ-ийн өрөөсгөл үйл ажиллагааны уршгаар сөрөг сэдэв л экологийн гэгдэх ташаа ойлголт бий болоод байгаагийн нэг илрэл энэ билээ.

**М**анай тогтмол хэвлэлийн экологийн нийтлэлийн гарчгуудыг төрөл зүйл, өнгө аясын хувьд ерөнхийд нь мэдээлсэн, нэрлэсэн, сурвалжилсан, асуудал дэвшүүлсэн, уриалсан, шүүмжилсэн, нийтлэл-уран сайхны гэж ангилж болмоор санагдлаа.

*Мэдээлсэн:* "Экологийн хохирлыг барагдуулах хуультай болно" ("Өдрийн сонин", 2005.11.11), "Дэлхийг бохирдлоос хамгаалах үйлсэд Монгол улс нэгдлээ" ("Өнөөдөр", 2005.12.17)

*Нэрлэсэн:* "Гялгар уут баяртай" ("Өдрийн сонин", 2005.11.21), "Уушгаа устгал утаагаар амьсгал" ("Ардчилал", 2008.11.13), "Гарз" ("Өнөөдөр", 2009.01.26), "Хордлоготой нийслэл" ("Өнөөдөр", 2008.03.18).

*Сурвалжилсан:* "Хатан туул "идээ бээрэндээ" баригдаж, биогийнхон өмхийрч дуусах нь" ("Ардын эрх", 2008.04.11).

"Замын-Үүдийхэн ундны усаар гачигдаж байна" ("Өнөөдөр", 2001.03.17), "Америкчууд нөхөн сэргээлтийг ингэж хийдэг" ("Өдрийн сонин", 2008.12.02).

*Асуудал дэвшүүлсэн:* "Экологийн гэмт хэрэг үйлдэгчдийг давраасаар байх уу?" ("Зууны мэдээ", 2005.11.11), "Утаанбаатараа Улаанбаатар болгое" ("Зууны мэдээ", 2005.09.28), "Туулын амьсгал тасарлаа, байгаль орчны сайдаа" ("Зууны мэдээ", 2008.05.13), "Шатсан ойгоо яах вэ, сайдаа?" ("Өнөөдөр", 2008.03.14).

*Уриалсан:* "Дэлхийд байхгүй монгол бөхөнгөө хамгаалъя" ("Үнэн", 2009.01.02), "Улаанбаатараа нүүлгэе" ("Үнэн", 2007.12.20), "Ногоон Токиогоос "ногоон хөшгийг" нь авчиръя" ("Зууны мэдээ", 2010.03.15).

*Шүүмжилсэн:* "Амьд цэцэрлэг устгаж байшин барьдаг улс дэлхийд Монголоос өөр байхгүй" ("Өнөөдөр", 2010.03.18), "Туул голын амь тасарч байгаад нийслэлийн удирдлагууд буруутай" ("Зууны мэдээ", 2010.03.24).

*Нийтлэл-уран сайхны:* "Зарааны хүү бөөдий эхдээ л зөөлөн" ("Өдрийн сонин", 2005.09.24), "Монгол оронд хур хайрла" ("Өнөөдөр", 2010.03.22), "Алтны хараалд өртсөн Улаан тайгын эмгэнэл" ("Өнөөдөр", 2010.03.31).

Экологийн нийтлэлийн гарчигт ажиглагдаж буй нэг дутагдал нь дэндүү ерөнхий байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл асуудлаа хүнтэй холбож өгөөгүй, тэрхүү зүйл нь хүний амьдралд хэрхэн нөлөөлөхийг хэлж өгөөгүй, уншигчдын

мэдэх зүйлтэй харьцуулж, зүйрлээгүй учраас тэдэнд хүрч нөлөөлөх тал дээр дутагдалтай байна. "Утаатай Улаанбаатар, өвчтэй ирээдүй" ("Өнөөдөр", 2009.01.26), "Агаарын бохирдлоос болж хүн амын эрүүл мэнд доройтож, богино наслах эрсдэл нүүрлэж байна", "Ирээдүйн амьдралд минь баталгаа алга" ("Зууны мэдээ", 2010.02.03), "Дархан цаазат газрын маань экосистем алдагджээ" ("Үндэсний шуудан", 2010.02.05) зэрэг гарчгийн агуулга бодит үнэнд нийцэж байгаа бөгөөд "хүн амын эрүүл мэнд доройтох, богино наслах эрдсэл", "өвчтэй ирээдүй", "экосистемийн алдагдал" гэдэг ойлголт уншигчдад энгийн, хүртээмжтэй тусч байна. Гэхдээ манай сэтгүүлчид экологийн нийтлэлийн гарчиг, агуулгаа нь хүнтэй

«

*Манай тогтмол хэвлэлийн экологийн нийтлэлийн гарчгуудыг төрөл зүйл, онго аясын хувьд ерөнхийд нь мэдээлсэн, нэрлэсэн, сурвалжилсан, асуудал дэвшүүлсэн, уриалсан, шүүмжилсэн, нийтлэл-уран сайхны гэж ангилж болно.*

»

тэр болгон холбож өгдөггүй дутагдал байгааг анхаарууштай юм. Жишээлбэл "Улаанбаатарын утаа үр удмыг тань тасалж мэдэх нь" ерөнхий гарчигтай "Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлоос болж бие нь ногоорсон, эсвэл эдгэшгүй эмгэгтэй хүүхдүүд төрж байна" ("Нийгмийн толь", 2009.11.30) дэд гарчигтай нийтлэл нь экологийн нийтлэлийн багагүй хувийг эзлэх утааны тухай дээрх гарчгуудаас арай өөрөөр өгсөн байгаа юм.

Уншигчдын анхаарлыг гарчгаар дамжуулж үндсэн мэдээлэлд татах, дэвшүүлсэн асуудлаа улам хурц сонирхолтой болгох зорилгоор сэтгүүлчид

уран сайхны арга, хэвшмэл хэллэг, зүйр цэцэн үг, толгой холболт, харшуулал зэргийг ашигладаг. Тухайлбал "Сайн байна уу, угааран Улаанбаатар минь" ("Ардчилал", 2008.12.23), "Түйрэнг дарах нь тийрэнг дарахын үлгэр үү" ("Зууны мэдээ", 2003.11.15), мөн толгой холбосон "Зэрлэг гахайг эрлэгт бүү илгээ" ("Зууны шуудан", 2008.02.28), "Уйлах ч нулимасгүй Улаанцутгалан" зэрэг ийм гарчгууд нь асуудлаа оновчтой илэрхийлж, хүний сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр болж чадсан байна. Дашрамд хэлэхэд нийтлэл уран сайхны төрлөөр бичсэн, танин мэдэхүйн шинж чанартай экологийн нийтлэлүүд бичлэгийн ур чадвар, агуулга сэдвийн хувьд сайн болдог нь судалгаагаар тогтоогдсон нь бий.

Түүнчлэн хүний ярианаас тасалж авсан хэллэгүүдээр гарчиглах нь ярилцагын төрөлд их байна. "Цөлжилт нэг улсын биш дэлхийн асуудал болсон" ("Зууны мэдээ", 2010.04.04), "Ундны усаар шавар зуурч, машинаа угаадаг улс Монголоос еер байхгүй" ("Үндэсний шуудан", 2010.01.19), "Байгаль орчингүй хөгжил гэж байхгүй" ("Өдрийн сонин", 2008.04.08) гэх мэтээр ярилцагчийн ярианаас авсан гарчиг түгээмэл байна.

### Дүгнэлт

Экологийн сэдэвт нийтлэлийн гарчиг энгийн бөгөөд товч байх сэтгүүл зүйн эхний дүрмийг манай сэтгүүлчид баримтлах шаардлагатай байгааг бидний судалгаа харууллаа. Бичиж байгаа зүйл нь уншиж байгаа хүнтэй тэр болгон холбогдохгүй байгаа нь гарчгийн үр нөлөөг бууруулаад зогсохгүй нийтлэлийн ач холбогдлыг багасгаж байна.

Хэтрүүлэл ихтэй, сүржин гарчиг экологийн нийтлэлийн дүр төрхийг тодорхойлж байгаа нь тэнцвэр барих, бодит байдлыг үзүүлэх, зарчмаа хазайлгах төдийгүй, нурж сүйрч байгаа байгалиа хамтын хүчээр аврах, хамгаалах үндсэн зорилгоо биелүүлэхгүй байгаа юм.

Экологийн нийтлэлийн гарчгуудыг мэдээлсэн, нэрлэсэн, сурвалжилсан, асуудал дэвшүүлсэн, уриалсан, шүүмжилсэн, нийтлэл-уран сайхны гэж ангилж авч үзлээ. Энэ нь ямар төрөл зүйлээр бичигдсэнээс шалтгаалж тухайн төрөл зүйлийнхээ өнгө аясыг гаргасан гарчиг байх нь ажиглагдлаа. Ярилцлагын төрөлд хэрэглэдэг хүний ярианы хэсгээс аван гарчигласан хэв маяг экологийн сэдэвт ярилцлагад мөн түгээмэл ажиглагдаж байна. Нийтлэл-уран сайхны төрлөөр бичигдсэн гарчиг сонирхолтой, хүртээмжтэй төдийгүй нийтлэл нь хүний сонирхол татаж, бичиж буй зүйлийнхээ мөн чанарыг сайн гаргаж өгсөн байдаг. Тэр тусмаа амьтдын амьдралыг харуулсан манай нэрт сэтгүүлч Ж.Мягмарсүрэн, Ж.Гангаа, Ж.Цэвээнхэрлэн, Ч.Чулуунцэцэг нарын нийтлэл, тэдгээрийн гарчиг нь экологийн сэдэвт нийтлэлийн шилдэг жишээ болдог. Гагхүү мэдээллийн, асуудал дэвшүүлсэн, задлан шинжилсэн төрлөөр бичигдсэн нийтлэлийн гарчгийн ур чадвар, үр нөлөөг сайжруулах асуудал экологийн сэтгүүл зүйн тулгамдсан асуудлын нэгэнд зүй ёсоор тооцогдож байгаа юм.

### Ишлэл

<sup>1</sup> Чойсамба Ч. 2000. Монгол сонин мэдээ. УБ., 90 дахь тал.

- <sup>2</sup> Дамбажав И., Зундуй Л. 1989. Сонин гаргах урлаг. УБ., 76 дахь тал.  
<sup>3</sup> Чойсамба Ч. 2000. Монгол сонины мэдээ. УБ., 110 дахь тал.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Амврхүү О. 2000. Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз, уламжлал шинэчлэлийн асуудал. УБ.
2. Ариун Л. 2008. Монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэл. УБ.
3. Данзан Г. 2002. Экологийн үндэс. УБ.
4. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
5. Чойсамба Ч. 2000. Монгол сонины мэдээ. УБ.
6. Чойсамба Ч. 2002. Экологийн сэтгүүл зүй. УБ.

#### Summary

Our survey has shown that journalists must note the titles of ecology themed articles should be ordinary and brief. The articles often are not connected to the readers, which results the influence of the title is reduced.

Too much excess in the title affects the purpose of the ecological articles in balancing, showing the reality, inclining the principles, protecting the devastated natural environment. The titles of ecological articles are divided into: informative, challenged, reported, named, interrogation /interrelated, criticized.

The titles of articles are determined by which genre journalists choose to write. It's common to use quotation from an interview as the title of an ecological interview genre is more interesting, effective and can reflect the affinity.